

Mongolian Buddhism: Animals, Plants and Bioethics

4th International Conference on
Aspects of Mongolian Buddhism

October 20-21, 2022, Budapest

Abstracts

Edited by

Birtalan Ágnes, Balogh Mátyás, Rákos Attila, Simonkay Zsuzsanna



Eötvös Loránd University, Faculty of Humanities

- Department of Mongolian and Inner Asian Studies
- Research Centre for Mongolian Studies
- Budapest Centre for Buddhist Studies

In cooperation with:

- Gandantegchenling Monastery,
the Centre of Mongolian Buddhists
- Embassy of Mongolia in Budapest
- Dharma Gate Buddhist Church
- Ferenc Hopp Museum of Asiatic Arts
- Oriental Collection of the Library and Information
Center of the Hungarian Academy of Sciences

“Цас шуурга шуурахын цагт өөр бусдыг тэтгэх ба санаа ямар мэт шүтэх ёс оршив” хэмээх судрын тухай

Л. АЛТАНЗАЯА

Монгол Улсын Боловсролын Их Сургууль

Монголын бурханы шашны түүхэнд эрдэмтэн мэргэд олон тооны ном судрыг орчуулж, туурвин хэвлэж, түгээн дэлгэрүүлсээр ирсэн. Тэдгээр бүтээл туурвилын нэгэн жишээ болох “Цас шуурга шуурахын цагт өөр бусдыг тэтгэх ба санаа ямар мэт шүтэх ёс оршив” хэмээх монгол бичгийн судар нь монголчуудын соёл уламжлалд холбогдох юм. Уг судар нь “Арван зүгийн ертөнцийн амьтан бүхийг үргэлжид энэрэгч блам бурхан гурван эрдэнэд мөргөмүй. Эдүгээ шуурга дор арга өгүүлэх нь, энэ мэтийн зовлон гэдэг өөр өөрийн үйлс нисванисаас гарсан бүхий гэм үндэслэн гарахын ёзоор нь биеийг үнэнхүүдэн би-д барихаас гарах” хэмээн эхэлжээ. Улмаар “үхрийн шагайн төдий шар тосыг буцалгаж ууваас өдрийн богиныг дагах(даах) амой” гэхчлэн малчны ахуй амьдралд тустай зарим зүйлийг тодорхой бичив. Судрын төгсгөлд “амны төдий хараал үгсийн оронд аль сайхан яруу сонсголт буюу ерөөлийг батдаж цэцэн ухаан нэмвээс сайн асанж” хэмээсэн нь сонирхолтой.

Зүүдний билэгдлээр өвчнийг таньж мэдэх тухай

Ч. БАДМААРАГ

Монгол Улсын Их Сургууль

Б. НАМХАЙ

Монгол Анагаах Ухааны Олон Улсын Сургууль

Ч. БАТНАЙРАМДАЛ

Монгол Анагаах Ухааны Төв Эмнэлэг

Зүүд нь бидэнд олон талын мэдээлэл өгдөг бөгөөд зөн совин болон хүний махбодын өвөрчлөл өвчний шинж тэмдэг, бидний нүдээр харж чихээр сонсож гараар барьж танин мэдэж болошгүй зүйлүүдийг ч зүүд хэлж өгдөг. Зүүдийг уламжлалт анагаах ухааны үүднээс өвчний сайн муу ёрын билэгдлээр олон мэргэд дээдэс зохиол бүтээл туурьван гаргасан нь өөр хоорондоо нэгэн адил бус өөр өөрийн таалалын үүднээс тайлан номлосон байдаг билээ.

Гараа өвчүүн дээрээ тавиад унтахад ямарваа нэгэн зүйл биеэн дээр дарж байгаа мэт зүүдлэгдэх. Салхи сэвэлзэн модны навчыг хийсгэх дуу нь унтаж байхад зүүдээр дамжин бороо орж байгаа мэт зүүдлэгдэх. Ундны зүйлийг ихээр уугаад унтахад давсаг чинэрээд зүүдэнд хурьцал үйлдэхийг зүүдлэх. Бүжиг бүжиглэх гэх мэт хөдөлгөөн хийгээд биеэ халууцуулан унтваас ихэвчлэн хүмүүс эвдрэл хэмхрэл, айн цочих гэх мэт зүүд зүүдэлдэг энэ нь биеийн температур өндөрсөн байдлаасаа буцаад уул хэвэндээ орж байгаа шинж юм. Ямараа өвчний зүйлээр бие махбодийн өөрчлөлөөр биеэнд эвэршээл, зовиур тортвоос зүүдэнд өөрчлөлт ордог тул тэр бүхэн махбодийн уг шалтгаанаас ургадаг зүүд мөн. Анагаах ухааны үүднээс муу совинтой зүүд илэрэн гарах шалтгаан нь өвчний эрхээр гардаг бөгөөд “зүүдний муу сайн нь сэтгэлийн гүйх нүх сүвийг өвчин хааснар үзэгдмүй” хэмээсэн нь сэтгэл буюу тийн мэдэл орох хийгээд гүйх нүх сүв нь хавдах буюу судлын гуурсууд хаагдах болон гэмтэснээр үргэлжийн гүйж чадахгүй болсноор зүүд мэт үзэгддэг байна. Өвчний улмаас зүүд үзэгдэх нь лавтай бөгөөд энэ нь хий, шар, бадган гурван хорлогч гэмийн өвчний байдлаас адилгүй байдаг бөгөөд давтамж болон үргэлжлэх хугацаа нь ч адилгүй байдаг. Муу зүүдний шинж тэмдэг нь ямар махбодын өвчин дийлэнх байна түүний эрхээр даган зохилдсон зүүд урган гаргна. Зүүд нь зөвхөн ямар нэгэн өвчний улмаас заавал гардаг юмуу гэвэл тийм байх алба үгүй юм. Мөн хувь хүний гурван гэмийн их багийн шалтгаанаас болж хий дийлэнх өвөрчлөлтэй хүнд хийн зүүд, шарын өвөрчлөл ихтэй хүнд шарын зүүд, бадган дийлэнх өвөрчлөлтэй хүн бадганы зүүд зүүдлэх нь элбэг байдаг. Зүүдийг “мээвшаллун”-д хийний төрлийн зүүд нь газар зүг бүхэн зүлэг, намганд эд бүгд байх бөгөөд тэдгээр нь хөх өнгөтэй болон хувцас хэрэглэл нь хөх болон хар, хар шувуу дүүлэн нисэх, морь унах, хөх өнгийн сайхан зүйлс, зүүд нь бодитой байснаа эвдрэх мэт зүүдлэгдэх нь хийний зүүд болой. Шарын төрлийн зүүд нь гал бадрах хийгээд хувцас хэрэглэл, амьтан, эд зүйлс нь ихэвчлэн шар, улаан байх бөгөөд алгуур баттай байх түүнээс айх нь шарын зүүд болой. Бадганы төрлийн зүүд нь ус болон цас зүг бүхэн нь цагаан цагаан хувцас, цагаан заан, цалин цагаан мөнгө, сувд зэрэг эрдэнийн зүйл зүүд нь ихэвчлэн айн явах үйлийг үйлдэх хийгээд зүүд нь үргэлжлэл нь удаан байдаг.

1. Зүүдийг биеийн 3 махбодийн өвөрчлөлтэй харьцуулан эмчилгээ оношлогоонд өргөн хэрэглэх нь үр дүн сайтай оношийн чухал шалгуур үзүүлэлт болохыг харуулж байна. Зүүд зүүдлэгдэх нь өвчний илрэлтэй шууд хамааралтай 89 % байсан.
2. Судалгаагаар хүний мөн чанарын зүүднээс, өвчнөөс шалтгаалж зүүд өөрчлөгдөж байгаа нь тогтоогдлоо.

Identifying Disease through Dream Symbols

BADMAARAG, Ch.

National University of Mongolia

NAMKHAI, B.

International School of Mongolian Medicine,
Mongolian National University of Medical Sciences

BATNAIRAMDAL, Ch.

Central Hospital of Mongolian Medicine,
Mongolian National University of Medical Sciences

Dreams provide us with many aspects of information, including intuition symptoms of human temperaments and diseases, things that we cannot see with our eyes, hear with our ears and touch with our hands. From the point of view of traditional medicine, many sages have written about dreams as a symbol of good or bad diseases. However, they preached for their own sake, not the same. When you sleep with your hand on your chest, you dream that something is pressing on your body. The sound of the wind blowing the leaves of the tree, while sleeping, dreams as if it is raining in the dream. After drinking a lot and going to sleep, the bladder is strained, and dreams of having intercourse in the dream. When people go to sleep with their bodies warmed up by dancing usually, people have dreams of panic attacks and panic attacks, which is a sign that the body's temperature is returning to its normal state. Because of any disease, changes in the body cause changes in the body from pain to pain, so they are all dreams that arise from the cause of the body. From the point of view of medicine, the reason for the appearance of bad dreams is due to illness, and "the bad and good dreams are not seen when the pores of the soul are closed by the disease". This is because the pores of the mind or the mind enter and run because the pores become swollen or the vein tubes are closed and damaged. It seems like a dream.

It is certain that dreams are caused by disease, and it is different from the disease state of the three evils of wind, bile, and phlegm, and its frequency and duration are also different. The symptoms of a bad dream will be based on what physical illness is most prevalent. It is not necessary to say that dreams occur only because of some disease. Also, due to the causes of the three sins of an individual, it is common for a person with a lot of wind temperament to have air dreams, for a person with a lot of bile temperament, to have a yellow dream, and a person with a lot of phlegm temperament to have phlegm dreams. In the dream "Meevshallun", wind-type dreams are grass and swamps everywhere, they are blue and clothes are blue and black, black birds are flying, riding a horse, beautiful things in blue, the dream is broken from reality. Dreaming like this is a wind dream. A yellow-type dream is a fire, and clothes, animals, and objects are usually bile and red, and being afraid of it is a bile dream. Phlegm-type dreams are water and snow, white clothes, white elephants, wages, white silver, pearls, jewels, etc., dreams are usually about going on a journey, and the dream is long in duration.

1. A comparison of dreams with three temperaments of the human changes in the body shows that the widespread use of dreams in treatment and diagnosis is an important indicator of effective diagnosis. 89% of studies have shown that dreaming is directly related to the manifestation of the disease.
2. According to the research, it was found that dreams change depending on the nature of dreams and diseases.

First Food of People – A Buddhist Legend in the Mongolian Sources

BAREJA-STARZYŃSKA, Agata

University of Warsaw

Obtaining food and the problem of field cultivation were often subject to people's historical and mythological considerations. It has been treated, as well, by Buddhists, who included a legend about finding wild rice and its cultivation in their writings. The paper will present a study on how this theme was adopted by Mongolian Buddhists in the selected sources.

Сюжеты о Будде Майтрея в фольклорной традиции калмыков

БАСАНГОВА (Борджанова), Т. Г.

Калмыцкий Государственный Университет

Доклад посвящен легендам и преданиям калмыков о Будде Майтрея, записанных у современных сказителей. Это отдельная тематическая группа в жанре легенд и преданий. Несколько текстов о Будде Майтрея (калм. Мээдрин гегэн) обнаружены в репертуаре современных сказителей Т. С. Тягиновой, С. Бутаева, Ш. В. Боктаева, опубликованных в серии "Сокровища предков". В 2008 г. Калмыцким институтом гуманитарных исследований РАН была основана серия «Өвкнрин зөөр» («Сокровища предков»), призванная ввести в научный оборот произведения, относящиеся к фольклорной традиции калмыков. В калмыцких фольклорных текстах Будда Майтрея выступает как культурный герой. В стране, созданной Майтреей, люди будут ему поклоняться, в соответствии Учению Будды Майтрея будут вести святую жизнь, избавятся от нищеты, будут пребывать в радости и счастье. Согласно тексту предания о Будде Майтрее из репертуара Т. С. Тягиновой Будда Майтрея – это культурный герой, которому приписывают создание земли,

растительности, троекратного питание человека, пояса, человека и животных, а также Вселенной с луной, солнцем, волшебного напитка – *аршан*.

Хангайн нурууны тахилгат уул ус тэдгээрийн байгалийг хамгаалах буддын шашны уламжлалыг тодруулах нь

Б. БАТХУЯГ

Заяын хүрээ Төгс Баясгалант Буян Дэлгэрүүлэх Хийд

Монгол орны нутгийн төв хэсгээр 10 аймгийн нутгийг дамжин 700 гаруй км үргэлжилсэн том нуруу болох Хангайн нуруу нь дэлхийн усны хагалбар болдог газар зүй болон ёс заншлын олон онцлог өвийг хадгалсан бүс нутаг юм.

Судлагааны ажлаараа тухайн бүс нутагт хамаарах Төрийн болон орон нутгийн иргэд, лам хуварга нарын тахиж ирсэн уул, усны тахилга шүтлэгийн уламжлал, байгаль хамгаалах онцлог зэргийг тодруулахаар зорьсон юм.

Судлагааны ажлын агуулга нь (1) тухайн бүс нутагт хамаарах уул, усны тахилга, шүтлэгийн түүхэн уламжлал, шүтээн болох болсоны уг эх болон уул, усны эздийн тухай тодруулах, (2) буддын шашны уламжлалт тахилгын зан үйлээр дамжуулан ан, амьтан, ургамал, бодисыг хамгаалж буй байдлыг тодруулах, (3) орчин цаг үед тахилгын уламжлал хэрхэн хадгалагдаж буй зэрэг байх юм.

Культ Белого Старца (поклонение одухотворенной природе)

БИЧЕЕВ, Баазр

Калмыцкий Государственный Университет

Благополучие страны в представлениях простых кочевников связано с природной средой своего обитания. Хозяином этой среды почитался Белый Старец. О древнем происхождении этого культа свидетельствуют представления монгольских народов. Монголы Ордоса называют его “духом-хозяином скота”. У калмыков он известен как покровитель сайгаков. Покровитель охотников и рыбаков у сибирских народов – белобородый старик *Бай Байанай*. По представлениям монгольских бурят, снег на склонах горы – это спина Белого Старца греющегося на солнце. В алтайских и тувинских сказках Белого Старца называют хозяином всего Алтая. В эпосе калмыков хранителем табуна всегда выступает белобородый старец *Ак-Сахал*. В волшебных сказках тувинцев советчиком и помощником героя также выступает «седобородый старик, пастух хана».

В ходе распада тенгрианства на этнолокальные религиозные системы ‘черной веры’ *Ак-Сахал* из “духа-хозяина скота” перерастает в образ Белого Старца. В круг его подчиненных включаются многочисленные хозяева-эзены земных и хозяева-хаты водных локусов. В «Сутре Белого старца» местом его пребывания названа гора Плодовая. Его функция Владыки над всеми видами многочисленных и сверхъестественных хозяев земных и водных локусов в письменной традиции закреплена в формуле – “Усмиритель и покоритель [духов-хозяев] земли и воды” (*γazar usuni номоγодхон даруулун čidaqči*). Этот псевдобуддийский эпитет Белого старца, опосредовано напоминающий эпитеты самого Будды, неизменно присутствует во всех известных списках «Сутры Белого Старца».

“Bestiarium Mongolorum” Preliminary Remarks on an Ongoing Project

BIRTALAN, Ágnes

Eötvös Loránd University, Department of Mongolian and Inner Asian Studies

Following the example of European mediaeval compendiums introducing real and imagined creatures, I have been working for several years on compiling a comprehensive work dedicated to the animal world which the Mongols respect, fear and use for various purposes. Besides the well-known European bestiaries, the *Shan Hai Jin* (around the 4th century BC) also offers a vivid survey of mythological and existing beings that play significant roles in various spheres of the Chinese people’s life.

As for the Mongols, being the heirs of the nomadic belief system, the Indo-Tibetan Buddhism and some Chinese religious and philosophical ideas, a series of *emic* and *etic* sources deal with a wide range of concepts concerning the animals since the introduction of the writing systems (13th century onward) and the recording of the oral tradition (18th century onward). During the centuries that followed the collapse of the Yuan dynasty (1368), the Mongols scattered in a vast territory of Inner Asia, South Siberia, China and even Europe. Their cultural legacy absorbed several new assessments of the world and the animals (real and mythical). This rich, syncretic, and locally differing tradition comprises many attractive features of animals – essential in the collective and personal beliefs and mythologies.

The author aims to create a “bestiary” named “Bestiarium Mongolorum”, i. e. a comprehensive work devoted to the Mongols’ views and understanding of, and relation to the mythical and real animal world. The structure of the

research paradigm follows the classical mediaeval European bestiaries, i. e., description of animals' features – called in her studies as creating a “morphology”. Particular focus is directed on the terminology and the transformation of their roles and the contemporary survival or the “renaissance” of some old traditional aspects concerning the veneration and utilisation of some real or mythical *species*.

In the present paper, two case studies are demonstrated adjusted to the central topic of the conference, the wolf and the Garuda bird.

Социализмийн үед шашны эсрэг үзэл санааг МОНГОЛЫН ТОГТМОЛ ХЭВЛЭЛД ТУСГАЖ БАЙСАН НЬ

Б. Болд-Эрдэнэ

Монгол Улсын Их Сургууль, Сэтгүүлзүй, Олон Нийтийн Харилцааны Тэнхим

Монгол орноо 1921 онд Ардын Намын хувьсгалчид Зөвлөлт Оросын улаан армийн дэмжлэгтэйгээр манай нутагт дүрвэн орж ирсэн Барон Унгерн Штейнберг тэргүүтэй цагаантны хүчийг цохин, Нийслэл Хүрээг чөлөөлснөөр коммунист дэглэм тогтох нөхцөл орчин бүрэлдсэн юм. Тухайн үед Монгол орон 100 гаруй мянган лам хуврагтай, 600 орчим том хүрээ хийд, 1000 гаруй шашны хурлын жижиг дуган¹, 100 гаруй хутагт хувилгаадтай, тэднээс тамгатай 13 хутагт нь эзэмшилдээ 70 мянган толгой мал, 30 гаруй мянган ам бүл бүхий 7000 орчим өрхийг шавь болгон эрхшээж байжээ.

1924 оны байдлаар Халхын дөрвөн аймаг Их шавийн 3600 гаруй жасын мэдэлд 2 сая гаруй толгой малыг 50 000 гаруй хүн амтай 11 885 өрх маллаж байв². Нөгөө талаар Ардын засаг тогтох үед Богд хаан шашин төрийн тэргүүн байсан, буддын шашин монголчуудын оюун санаа, амьдралын хэв маяг, ертөнцийг үзэх үзэлд оройлох нөлөө үзүүлж, сүм хийд нийгмийн амьдрал харилцаанд ноёлох байр суурийг эзэлж байлаа.

Тиймээс МАН-ын мэдээлэл, ухуулга сурталчилгааны гол асуудал, үзэл бодлын тэмцлийн тэргүүн орон зай нь шашны эсрэг үзэл санааг олон нийтэд түгээх байв. Ийнхүү 1921 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр Ардын засгийн газрын тогтоолоор Богд хааны төр шашны эрхийг зааглан тогтоосон Тангаргын гэрээ хэмээх эрхзүйн баримтыг баталсан. Энэхүү гэрээний нэгдүгээр зүйлд “Монгол Улсын Богд хаан Жавзандамба хутагт шарын шашны богд эзэн болох тул улс төрийн хэрэгт холбогдолгүй шашны бүх хэргийг хязгааргүй эрхэлбэл зохино”³ хэмээн зааж, төр шашны эрхийг тусгаарлажээ.

МАХН-ын Төв хороо, Засгийн газрын төв хэвлэл “Ардын Эрх” сонинд (1924–1925) томоохон нэр хүндтэй хутагт хувилгаадын шашин номыг үл дээдлэн самуун явдал, шалиг завхайрал, эд хөрөнгийн шуналд автаж байгаа болоод ядуу доод лам нарыг татах ухуулга сурталчилгаа хийж байв.

МАХН болон Залуучуудын эвлэлийн Төв хорооны хэвлэл “Үнэн” (1924–өдгөө хүртэл) сонинд намаас удвшүүлсэн сүм хийдийн мал хөрөнгийг хураах ажлын үед ард олны сүсэг бишрэлийг алдадагдуулахгүй байх үүргийг хүлээхийн зэрэгцээ лам нарыг нийгмийн давхаргын хувьд үгүй болгох (ангийн тэмцэл нь коммунист үзлийн гол онол байдаг) ингэхдээ нэгдүгээрт өмч хөрөнгөгүй, хоёрдугаарт том хутагт хувилгаад болон залуу ядуу лам нарын дунд хагарал зөрчил бий болгох, улмаар хар энгийн иргэн болгох сурталчилгааг онцолж байв. Мэдээллийн стратегийн хувьд зорилгот бүлэгт (ядуу доод лам, малчин ардууд, ядуус) түлхүүр мэдээллийг (жасын хураасан мал хөрөнгийг ардуудад тараах, хуваарилах) хүргэж олон нийтийн санаа бодолд Ардын засгийн талаарх эерэг ойлголт төсөөллийг (Ардын засаг бол доодос ядуусыг тэтгэдэг, мөлжигчдийг устгаж буй) төлөвшүүлэхэд оршиж байлаа.

1931 онд хэвлэгдэж эхэлсэн “Монголын бурхангүйчүүдийн эвлэл” сэтгүүл нь хэт хувьсгалч зүүнтний засаглалын үед Коминтерн, Зөвлөлт засгийн шууд шахалт нөлөөгөөр шашингүйн үзлийг сурталчилж байв. Гэвч буддын шашны мөн чанар, монгол хүний сэтгэлгээнд үл нийцсэн, зөвлөлт маягийн ухуулгын арга хэлбэрийг шууд хуулбарлаж байснаас үр нөлөө үзүүлж чадаагүй.

1932 оны шашин, соёлоо хамгаалсан үндэсний хөдөлгөөн зэвсэгт мөргөлдөөний дараа МАН, Засгийн газрын хэвлэлүүд шашны эсрэг “мэдээллийн зөөлөн бодлого” барьж, залуу доод лам нарыг энгийн иргэн болгох, ажил хөдөлмөр эрхлүүлэх, бичиг үсэгт сургах, европ эмнэлгийн ач тусыг тайлбарлах, тэдний цэргийн татварыг хөнгөлөх зэрэг мэдээлэл сурталчилгааг онцолж, төрөлжсөн хэвлэл болох “Лам нарын сэтгүүл”-ийг хэвлэж эхлэв.

Гэвч 1937–1939 онд Коминтерн, Сталины шууд шахалт, заавар, Зөвлөлт Оросын дотоод хэргийн яамны оролцоотойгоор олон мянган лам нарыг хомроглон устгаж, сүм хийдийг нураан, шашны номыг галдан шатаасан түүхийн “хар толбо” болох их хэлмэгдүүлэлт ид гаарсан юм. Ийнхүү шашны үзэл санааны эсрэг ухуулга сурталчилгааны бодлого, үйл хэрэг зорилгодоо хүрэлгүй аллага хядлагын аймшигт аргаар лам нарыг нийгмийн давхаргын хувьд устгасан.

¹ БНМАУ-ын түүх II дэвтэр. Улаанбаатар 1966, т. 257.

² Дашзэвэг, МАХН-аас шарын шашин, түүний үлдэгдлийн эсрэг явуулсан тэмцлийн зарим асуудал. Улаанбаатар 1976, т. 8.

³ Ардын засгийн газраас 1921–1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд УБ., 1956, тал 69

Гэвч монголын ард түмний оюун санаа, итгэл үнэмшил, зан заншилд буддын шашны нөлөө хэвээр байсаар 1990 оныг хүрч дахин сэргэсэн тул социализмийн үеийн ухуулга сурталчилгаа ажмлжилтад хүрээгүй хэмээн дүгнэж болно.

Шаравтар лидрийн (*Sophora flavescens soland*) Тархац, тарималжуулсан судалгааны дүн

БУЛГАН, А. – ЖАМБЯНДОРЖ, Х.
ЛИГАА, У. – СААРАЛ, Н.

Монгол Улсын Хөдөө Аж Ахуйн Их Сургууль,
Мал Аж Ахуй, Биотехнологийн Сургууль

Шаравтар лидрийг монгол уламжлалт эмнэлэгт олон зуун жилийн турш хэрэглэж иржээ. Орчин үеийн судалгаагаар лидер нь эмийн 181 жоронд орж монгол уламжлалт эмнэлэгт жоронд орох давтамжаараа 38-р байранд ордог. Байгаль цаг уурын хүчин зүйлээс гадна хүн амьтны зохисгүй үйл ажиллагаанаас болж шаравтар лидрийн тархалтын хүрээ хумигдаж байна. Улаан номонд орсон нэн ховор Шаравтар лидрийн тархац, ургах орчныг судлан тогтоож, Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаанд байрлах судалгааны төвийн цэцэрлэгт амьд цуглуулгыг бүрдүүлэх, генофондод үр болон үржлийн материалаар хадгалах, тарималжуулах зорилго тавин ажилласан.

Шаравтар лидрийг Дорнод аймгийн Баяндун сумаас баруун тийш 30 орчим километрт Улиас, нарсан холимог ойгоос 3 үндэслэг ишийг 2003 онд цуглуулж, Хэнтий аймгийн Дэлгэрхаан сум, Хэрлэнбаян-Улаанд байрлах судалгааны плантацид тарьж цаашид үржүүлэх эх материалтай боллоо. Шаравтар лидрийн үрийг урьдчилан бэлтгэсэн талбайд 20–25 см өргөн, 25–30 см гүн, 33 м урттай хагалж боловсруулсан шуудуунд ургамал хооронд 5–6 см, мөр хооронд 60–65 см зайтайгаар 2–3 см гүнд суулгасан. Шаравтар лидрийн сэргэн ургалт 5 сарын хоёр дахь 10 хоногт эхлэн, үр боловсролтын үе шат 7 сарын дундаас 9 сарын эхэн хүртэл үргэлжилсэн. Нийт вегетацийн хугацаа 110–117 хоног байлаа. Шаравтар лидер нь тухайн нутагт тарималжих бүрэн боломжтойг тогтоолоо.

Burqan-u šasin-u nölüge mongyol uran jokiya-du günjegei nebtaregsen-ü keden šatu

BÜRENBAYAR

Töb-ün Ündüsüten-ü Yeke Suryayuli

“Цэцэн тэнэгийн судар” (mDzangs blun mdo)-ын дүймингийн тухай

“Цэцэн тэнэгийн судар” (mDzangs blun mdo)-ын дүймингийн тухай

Д. БҮРНЭЭ

Монгол Улсын Их Сургууль,
Монгол Хэл, Хэлшинжлэлийн Тэнхим

Монгол Ганжуурын 90 дүгээр ботид байдаг Бурхан багшийн урьд төрлийн намтар түүхийг үлгэр домгийн хэлээр уран яруу өгүүлсэн “Шулуун онолт” буюу “Үлгэрийн далай” (тө. mdo mzhang blun) хэмээх судар монголчуудын дунд их дэлгэрсэн билээ. Тус судрын дөрвөн зүйлийн орчуулгаас Ширээт гүүшийн орчуулга гар бичмэл, бар хэвлэлээр өргөн тархжээ. Бид энэхүү илтгэлдээ академич Ц. Дамдинсүрэнгийн гэр музейд хадгалагдаж байгаа “Үлгэрийн далай” судрын дөрвөн зүйл дүймин (тө. btus ming, мо. түүвэр нэр)-гийн эх бичгийн онцлог, судруудын холбоо хамаарлын талаар өгүүлнэ. Олны дунд дэлгэрч танил болсон, буддын шашны нэр хүндтэй төвөд ном судрыг уншиж тайлахад зориулан дүйминг найруулсан байдаг. Ихэвчлэн гар бичмэлээр тааралдах эдгээр сударт буддын шашин, гүн ухааны холбоотой хатуу үг хэллэгийг түүвэрлэн монгол хэлнээ орчуулсан байх учраас нэг зүйлийн төвөд- монгол хадмал түүвэр үгс юм. Дүйминд төвөд үгийн монгол орчуулгыг ихэвчлэн төвөд бичгээр үсэгчилж бичсэн байхаас гадна бичвэрийн тухайд худам монгол бичгийн зөв бичих зүйгээс нэлээд холдсон, ярианы хэлэнд илүү ойртсон тал ажиглагдана.

Монгол лам нарын төвөд хэлээр бичсэн “Тэмээ”-тэй холбоотой ном бүтээлийн тухай

Р. БЯМБАА

Варшавын Их Сургууль

Монголын эрдэмтэн мэргэд, лам нар зөвхөн орон хийдэд шавилан сууж, баясалгал, шашины ном үйл бүтээл туурвиад суусангүй тэд тухай үеийнхээ нүүдэлчин ард түмнийхээ аж амьдрал, эрүүл мэнд, амьдарч буй газар орон байгаль дэлхий, амьдаралтай холбоотой эрхэлдэг аж ахуй тэргүүтэнд нь биеэр бодитой тус нэмэр болдоггүй ч шашин номын талаас тус нэмэр болох үүднээс ахуй амьдралтай нь холбоотой болон амьдрах арга ухааныг сургасан олон сургаал, зан үйлийн холбоотой ном бүтээл монгол, төвөд хэлээр туурвисан байдаг. Түүний нэг тод жишээ бол нүүдэлчин ард түмний гол аж ахуй болсон таван хошуу малыг ган, зуд, хүчтэй салхи, бороо, цас, мөндөр тэргүүтэн байгалийн янз бүрийн аюултай үзэгдэл болон элдэв зүйлийн хижиг тахал, өвчин эмгэг согог, чоно нохой тэргүүтэн араатан амьтан, хулгайгаас хамгаалах, өсгөж үржихэд нь зориулан ном бүтээл туурвисан байдаг. Энэ удаа нүүдэлчин ард түмний гол аж ахуй болсон таван хошуу малтай холбоотой төвөд хэлээр бичсэн ном бүтээлийг бүхэлд нь авч үзэх боломжгүй маш их өргөн хүрээтэй асуудал тул зөвхөн “Тэмээ”-тэй холбоотой Монгол лам нарын төвөд хэлээр бичсэн зохиол бүтээлийн талаар өгүүлнэ.

Ер нь “Тэмээ” нь таван хошуу мал дотор хамгийн том сүрлэг, олон хоногийн өл даах чадвартай, хүч тэнхээтэй, сүр бараатай харагдах боловч өсөлт удаантай, маш их эмзэг, амархан өвдөмтгий амьтан. Тийм учраас Монголын эрдэмтэн лам нар төвөд хэлээр бичсэн “Тэмээ”-ний охин тэнгэр Гүнжинлхам (Tib. Dgun gyi rgyal mo'i [Dgun gyi lha mo] sangs mchod) бурханы сан тахилга, тэмээний сан, даллага, тэмээний өвчинг эмчлэх арга засал тэргүүтэн ном бүтээл нэлээд байх тул тэдгээрийг танилцуулах болно.

Begejing-ün modun bar-un “Geser-ün tuyūji”-daki qatud-un dūri-dū tusyaydaysan burqan-u šasin-u nölöge-yi sinjilekü ni

СҮЙЛГЭН

Töb-ün Ündüsüten-ü Yeke Suryayuli

Монгол лам нарын төвөд хэлээр бичсэн “Тэмээ”-ний охин тэнгэр Гүнжинлхам (Tib. Dgun gyi rgyal mo'i [Dgun gyi lha mo] sangs mchod) бурханы сан тахилга, тэмээний сан, даллага, тэмээний өвчинг эмчлэх арга засал тэргүүтэн ном бүтээл нэлээд байх тул тэдгээрийг танилцуулах болно.

Öljei-yin Lubsang qururči-yin Bodi mergen qayan-u üliger-dü tusyaydaysan burqan-u šasin-u jarim üjelte oyilyalta

СОГТУ

Töb-ün Ündüsüten-ü Yeke Suryayuli

Монгол лам нарын төвөд хэлээр бичсэн “Тэмээ”-ний охин тэнгэр Гүнжинлхам (Tib. Dgun gyi rgyal mo'i [Dgun gyi lha mo] sangs mchod) бурханы сан тахилга, тэмээний сан, даллага, тэмээний өвчинг эмчлэх арга засал тэргүүтэн ном бүтээл нэлээд байх тул тэдгээрийг танилцуулах болно.

Үйлийн үр ба хүн, байгалийн шүтэлцээ

Б. ДАРАМБАЗАР

Цогт Цагийн Хүрдэн Соёлын Төв

Хүн төрөлхтөн байгаль дэлхийгээ түшиж, түүнийхээ үр шимээр тэжээгдэн тэтгэгдэж амьдардаг. Хүний үйл үйлдэл бүр байгаль дэлхийд нөлөөлж байдаг харилцан шүтэлцээтэй юм.

Буддын ухаанд хүн байгалийн шүтэлцээг “Үйлийн үрийн онол”-оор авч үзэж маш тодорхой тайлбарласан байдаг. Үйлийн үрийн онол бол Буддын ухааны амин сүнс билээ.

Бид энэхүү илтгэлдээ Монголын сэтгэгч, гүн ухаантан Лувсаньяндаг ламын туурвисан “Үйлийн үрийн саруул толь” номыг эш үндэс болгож “хүн байгалийн шүтэлцээг авч үзэх, ялангуяа хүний зөв, буруу үйлдэл байгаль дэлхийд хэрхэн нөлөөлдөг болохыг тодруулах, улмаар байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах хүний зохист үйлдэл, зөв харилцааг хөндөн өгүүлж, шинэ санаа дэвшүүлэн тавих” юм.

Чингэхдээ бид Монгол Ганжуураас “Үйлийн үр”-ийн тухай айлдсан ном болон бусад холбогдох эх сурвалжуудыг ч харьцуулан судална.

Монгол нутагт бурханы шашин анх дэлгэрсэн түүхийн асуудалд

П. ДЭЛГЭРЖАРГАЛ

Монгол Улсын Их Сургууль, Түүхийн Тэнхим

Хүннүчүүдийн гол шүтлэг нь тэнгэр шүтлэг, бөөгийн шүтлэг байсан боловч Хүннү гүрэн өргөжин тэлж, торгоны замыг дангаараа хянах болсон үеэс бурханы шашины нөлөө орж ирэх болсон хэмээн үзэж болно. НТӨ 121 онд Хань улсын Хо Цюйбин жанжин Хөхнуур, Ганьсу дахь Хүннүгийн Сютү ванг довтлон цохиж, түүний алтан хүн (金人 jinren)-ийг олзолсон талаар “Түүхэн тэмдэглэл”-ийн Хүннүгийн шастирт тэмдэглэсэн байдаг. Энэхүү “алтан хүн”-ийг Буддагийн хөрөг хэмээн зарим судлаачид үздэг билээ.

Сяньбийн угсааны гурван улсын үед, Жужан, Умард Вэйд бурханы шашин өргөн дэлгэрсэн тухай сурвалжийн болон археологийн баттай мэдээ баримт үлджээ. Умард Вэй улсад бурханы шашин өргөн дэлгэрч, төрийн зүгээс дэмжих болсон. Умард Вэй улсын нийслэл Пинчэн хот нь буддын шашины томоохон төв болж, буддизм түгэн дэлгэрэхэд чухал үүрэг гүйцэтгэж байв.

1997 онд Турфаны Янхайн оршуулгаас Турфан дахь Гаочан улсаар дайран өнгөрөх Жужаны болон баруун орны элч нарын бүртгэл олдсон нь чухал ач холбогдолтой юм. Элчийн бүртгэл тэмдэглэлээс үзвэл, Гаочаны ванлиг нь Турфан, Таримын сав нутагт Жужан улс хяналтаа тогтоох гол түшиц болж байсан төдийгүй Жужан улс Таримын сав, умард Энэтхэгтэй харилцахад чухал үүрэгтэй байсан ажээ. Тухайлбал, Элчийн тэмдэглэлд, 474 оны 12 сарын 2-нд Энэтхэгийн Удяна (Udyana)-ын элч Жужанаас буцахдаа Гаочаныг дайрсан. 475 оны 3 сарын 14-нд Энэтхэгийн Брахман улсын элч Карашар руу явсан тухай тэмдэглэжээ. Энэ нь Умард Энэтхэгээс Гаочанаар дайран, тэндээсээ Тэнгэр уулын салаа Богд уулыг даван Жужан руу аялан явдаг торгоны замын умард салаа зам байсан нь тодорхой болж байна. Энэ зам нь худалдаа арилжааны чухал зам болж байсан төдийгүй, бурханы шашин түгэн дэлгэрэх зам болж байсан хэмээн үзэж байна.

Ecological Initiatives of Buddhist Communities of Russia

DONDUKOV, Bato

East Siberia State University of Technology and Management,
Department of Organization and Management of Scientific Researches

The paper analyses the contemporary initiatives of various Buddhist communities of Russia aimed at improving the environmental situation. During expeditions to the republic of Buryatia, and Kalmykia of the Russian Federation we analysed the initiatives of the Traditional Buryat Buddhist Sangha connected to the forest fires in the Baikal region, the “social flock of sheep” initiative in support of rural believers, as well the activities of the Central Khurul aimed at improvement of the land degradation and desertification situation in the republic of Kalmykia. The studied cases showed that the local Buddhist leaders perform not only ritual but also ideological and collaborative functions as they engage other social and state organizations into environmental projects, ensuring their interaction.

Shastr ut dun: Kalmyk Religious Long-Songs

DORDZHIEVA, Ghilyana

Mongol American Cultural Association

Among Kalmyk *shastr ut dun* (long-songs with Buddhist themes) only a few texts with the horse description are known. However, these songs reveal important features. There is remarkable example with the same beginning, the same two initial lines ‘Malya tamgta born, Malya al'avlad naadna’ to start both long-songs with Buddhist themes and *uul'ldg ut dun* (wedding crying long-songs). Noteworthy both songs were sung to the similar tune.

Published and archival recordings of the *shastr ut dun* ‘Shankhagtah sharh morn’ will be observed. Comparison of external and internal images is presented only in the first stanza. In stanzas 2 and 3, the external and the internal image both are of Buddhist content. According to the classification of Á. Birtalan, a theme of Buddhist ritual can be distinguished. Probably, as the specific Kalmyk feature should be marked the prayer for protection (one of the performers mentioned that the songs was composed by soldier before World War I). Musical features, such as one-line melodic period (brief or short tune) and a narrow diapason connect these *shastr ut dun* with the earlier songs associated with the ritual.

Үлэмжийн чанарын үлэмж гүн агуулгаар сэрэхүй

Ц. ДОРЖДЭРЭМ

Санкт-Петербургийн Улсын Их Сургууль,
Монгол Түвд Судлалын Тэнхим

Дорнын их соён гэгээрүүлэгч Данзанравжаагийн суу билэг дундаршгүй гүн бөгөөд түүний бүтээл туурвилыг судлан эрэлхийлж тайлбарлан таниулахад нэгэн төрлийн нас үл хүрэх бөлгөө. Академич Ц. Дамдинсүрэн “Равжаа гайхамшигтай авьяас билигтэй нэгэн байсан төдийгүй түвд хэл, эртний судар бичгийн уламжлалыг

нарийн чанад барьдаг, мөргөл залбирлаар эхэлж ерөөл бэлгэдлээр бүтээлээ өндөрлөдөг Дорнын их мэргэдийн нэгэн юм”. Мөн эрдэмтэн Д. Цагаан “Равжаагийн Цаасан шувуу, Үлэмжийн чанар, Ичиг ичиг, Тэргэл сар зэргэ зохиол нь түвд монгол хэлээр уламжлан ирсэн нь нэн нандин бүтээл юм”. Равжаа зохиолдоо өөрийгөө Данзанравжаа, Лувсанданзанравжаа, Додмайрандол гэх зэргээр нэрлэн бичсэн байдаг. Энэ нь түвдэч Ч. Алтангэрэл гуайн тэмдэглэснээр “Сумади шасана дхрабра бухяна” гэж санскритаар Лувсанданзанравжаа гэсний угатай яг нийлэх юм. Додмайрандол гэдэг түвд нэр нь “Угаас өөрөө гэрэлтсэн” гэсэн үг байна. Тэрчлэн тойн дүрст өнөөх гайхал, Согтуу, Галзуугийн үг, Цагаан хэрээ, Тотийн үг зэргээр мөн л шүлэг зохиолдоо дурдсан нь гадна төрх байдлаас бус далд номын утга чанартай ажээ.

Ийнхүү их бичгийн эрдэмтэн мэргэдийн бие, бийрээ чилээн байж эмхлэн цуглуулж шүүн тунгаасан Их Хутагтын зохиол бүтээл эдүүгээг хүртэл дахин дахин баримтаглагдаж ирсэн нь сүсэг бишрэлийн дунгуйг түмэнтэй эргүүлж, сүлд хийморийг мянгантаа бадраах ажгуу.

Говийн догшин ноён хутагт хэмээх энэ гайхамшигт хүний таван бадаг бүхий Үлэмжийн чанар “сувдан хэлхээ”-г хүний орчлонд хүн болж төрөөд хүн шиг хүн байж хүний ёсоор амьдарч чадваас хүний орчлонгоос хүний ёсоор үдүүлэх жамтай юм хэмээн хамгийн энгийн учир шалтгаанаар хүлээн авах нь орчлонгийн “түнэр харанхуй”-д төөрөхгүй явах гэрэлт зам мөр болой.

1845 онд өөрийн байгуулсан Хамарын хийдийн архан талд нэг овгор шороон дээр суугаад Шамбалын ерөөл уншиж, “энд ирсэн хүн дараа төрөлдөө Шамбалын оронд очиж надтай уулзах ерөөл тавилаа” гэж айлдсан байдгаас үзвэл Монголын говьд дэлхийн энергийн цэг байгаа гэдгийг урьдчилан мэдэж байжээ. Хутагтын шүтдэг шүтээн нь эмэгтэй хүн, уран зураг, хун шувуу, яруу найраг, дигваранз буюу хилэнцэт хорхой байсан гэдэг.

“Миний Үлэмжийн чанар дууг нэг дуулахад мянган Дарь эх уншсантай тэнцэнэ” гэж тэрээр айлджээ.

An Analysis of the Implication of Animals in the Oracles of Lobsangdambijalsan (Mergen gegen) (Mergen gegen Lubsangdambijalsan-u silüg dayuu-du ileregsen amitan-u tuqai)

DURSGALT

Inner Mongolia Normal University

BORJIGIN Oyun

Inner Mongolia Normal University

OTOR

Inner Mongolia University

In Inner Mongolia, Mergen Juu more called III living Buddha Lobsangdambijalsan (Mergen gegen) hest song (“*Shüleg duu*”) and proverbs the lions, elephants, animals are repeated in the mythical dragon, phoenix, or image of various animals in Chinese zodiac, and the nature of pine, cypress, flowers and plants, such as the name of the plant, the significance of Buddhist truth can protect animal life, harmonious coexistence of man and nature can be a win-win truth. This paper focuses on the analysis of the relevant animal oracles and proverbs, and discusses the Buddhist monks through the secularized oracles and proverbs, which are rich in sentiment, contain philosophy, and have remarkable effects, to sing to future generations through the way of hymns chanting and oral singing, purifying people’s hearts and influencing society, so as to achieve the purpose of public education.

Ecological Significance of Tibetan Medicine on the Example of “The Atlas of Tibetan Medicine”

DORZHIGUSHAeva, Oyuna

East-Siberia State University of Technology and Management,
Department of Literature and Folklore Studies

DONDUKOVA, Galina

Siberian Branch of the Russian Academy of Sciences,
Institute for Mongolian, Buddhist and Tibetan Studies

Tibetan medicine is a unique system of healing, which was formed as accumulation and improvement of Chinese, ancient Indian and Arab medicine, together with traditional methods of healing practiced in Tibet itself. Tibetan medicine considers everything that surrounds a person as a possible cure or source of danger, depending on the dose, relevance, season, age and other factors. It treats a person as a balanced ecosystem, health as the harmony of all spheres of his life. The article aims to overview “The Atlas of Tibetan Medicine” which is kept in the funds of the National Museum of the Republic of Buryatia, Russia. We argue that The Atlas shows how important the ecological state of nature is for the health of a person, for the production of medicines and maintaining a healthy lifestyle in general.

Тахилга шүтээнтэй газар нутгийн аман түүхээс (Хэрлэн голын эх орчмын нутгийн жишээгээр)

М. ЭНХБААТАР

Соёл Урлагийн Их Сургууль

Энэхүү илтгэлдээ Хэрлэнгийн эх орчмын тахилга шүтээнтэй газруудыг төлөөлүүлэн Төрийн тахилгат Бурхан Халдун хайрхны тахилга, түүнийг сэргээсэн байдал, социалист нийгмийн үед хүмүүс хэрхэн тахилга шүтээнтэй уул устай харилцаж байв гэдгийг 2013 болон 2020 онд Төв аймгийн Мөнгөнморьт суманд хийсэн угсаатны зүйн хээрийн шинжилгээний материалд тулгуурлан, тэр нутгийнхны аман түүхээр тодруулах юм. Чингэхдээ Бурхан Халдун хайрхныг нутгийн иргэд их төлөв Хэнтий хайрхан хэмээн өгүүлж байгаа тул уг ёсоор бичив. Хэнтий хайрхантай холбогдох хүмүүсийн хэрэгцээ шаардлага нь ан ав, бэлчээр нутаг, шүтлэгийн хэлбэр гэсэн зүйлсээр илэрч байна.

Тухайн нийгэм, цаг үеийн үзэл суртлын хүрээнд уул овоогоо тахиж шүтэх нь хориотой байсан ч ард түмний дунд хүндэтгэлийн хэлбэр нь хадгалагдсан хэвээр байсныг гэрчлэх нэг жишээ нь Хэнтий хайрхан юм. Жил бүрийн товлосон өдөр нууцаар цуглан овоонд гарч, идээгээ өргөх, ан хийхгүй байх, онцгой зорилгогүй бол оройд нь гарахгүй ёстой байсан зэргийг нэгтгэн дүгнэхэд байгаль хамгааллын нэгэн цогц арга ажиллагааг тухайн үед нутгийн ард түмэн хэрэгжүүлж байсныг харж болох юм.

Улааны шашны “Гармава” урсгалын уул, овоог тахиж зан үйлийн онцлог

О. ЭНХЖАВХЛАН

Монгол Зохиолчдын Эвлэл

Монголчууд газар орон, уул ус бүхнийг эзэнтэй, хариуцан даасан лус, савдагтай хэмээн үзэж, уул овоог тахиж ирсэн уламжлалтай. Бурхны шашны бие даасан өвөрмөц чиглэл болох улааны шашны “Гармава” урсгал лус, савдаг, уул овоог тахиж, засал хариулга хийх тусгай арга, домтой. Илтгэлд гавж агсан Г. Диваасамбуу ламтны бичиж, хойч үедээ уламжилсан засал, домын номд тулгуурлан “Гармава” урсгалын уул, овоог тахиж зан үйлийн онцлогийг өгүүлнэ.

Гавж Гаржүдийн Диваасамбуу бол Бүгд Найрамдах Монгол Ард Улсад шашин, сүм хийдийн үйл ажиллагааг хязгаарлаж, дээд, дунд зиндааны лам нарыг давхаргыг хэлмэгдүүлэн устгасан 1930–1940-өөд онд Өвөр Монголын Зүүн Сөнөд хошууны хийдэд шавилан сууж, хурал номын ажлаа нэг ч өдөр таслаагүй хүн юм. Тэрбээр дэлхийн 2-р дайны дараа БНМАУ-д шилжин суурьшиж, 20-р зууны хоёрдугаар хагаст улааны шашны “Гармава” урсгалыг Монголд сэргэн дэлгэрэхэд онцгой үүрэг гүйцэтгэсэн.

Түүхэн ой санамж: Зүүнгар улсаас үлдсэн нэгэн хэллэг

Л. ЭНХСАРУУЛ

Өтвөш Лорандын нэрэмжит Их Сургууль, Могнол ба Төв Ази Судлалын Тэнхим

Монголчууд өнө эртнээс байгаль дэлхийгээ ажиглан шинжиж, зүй тогтол, хэлэмжийг нь аман зохиолдоо үлдээж ирсэн түүхтэй. Гэвч ихэнх зүйр үгнүүд нь чухам хэдий үеэс, ямар үйл явдлын улмаас хэлэгдэх болсон нь тодорхойгүй, цаашлаад зарим нь тодорхой бүс нутгийн хэмжээнд хэлэгдэх нь бий. Үүний нэг жишээ нь Увс аймгийн зарим дөрвөдүүдийн дунд хэлэгдэх 12 жилийн байгалийн давтамжтай холбогдох

үхэр жилд үрэгдэнэ (үймнэ),

бар жилд барагдана,

туулай жилд туугдана хэмээх үг юм. Сурвалжийн мэдээнээс үзвэл энэхүү хэллэг нь 1733 онд зохиогджээ. Зохиогдох болсон учир шалтгаан нь 1697 оны улаагчин үхэр, 1721 оны цагаагчин үхэр, 1733 оны харагчин үхэр жил малд гарсан хижиг өвчний давтамж, үүнээс үүссэн гачигдал, хүнд хэцүү байдал аж. Энэ тухай 1733 оны 10 сарын 21-нд Ангирт харуулаас Чин улсад даган орсон хойдын Үйзэн хошуучийн харьяат, Эмилд нутаглан суусан 31 настай Төгс хэмээгч мэдүүлсэн нь манж сурвалжид үлджээ. Мэдээнд, “*өнгөрсөн жил Эрдэнэ зууд дарагдаж хойш очсоноос олны зохиосон цуу үг, бар жилд барагдмуй, үхэр жилд үрэгдмуй, хулгана жил хурагдмуй, туулай жилд тогтмуй хэмээн нүгэлт үг үүссэн ар араасаа өгүүлэх билээ*” гэдэг. Уг хэллэг нь аман зохиолын бусад төрлийн нэгэн адил хөгжлийнхөө явцад агуулга нь хувьсан өөрчлөгдсөн шинж ажиглагдана. Зүүнгар улсын ард түмний дунд үүсэн, тархсан энэ хэллэг нь

– Ховд аймагт төвлөн суух торгууд, хошууд нь 1771 онд Ижил мөрнөөс нүүж ирсэн учир Зүүнгартай холбогдохгүй. Захчин нь Зүүнгар-Манжийн хил дагуу, мянгад нь Зүүнгар-Хасагийн хил дагуу амьдарч байсан учир Или, Эмил зэрэг Зүүнгарын төв нутагт үүссэн хижиг өвчин, гачигдлыг биеэр туулаагүй.

– Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Архангай аймгийн Өлзийт сумын өөлдүүд нь 1703 онд Чин улсад даган орсон Цоросын ноён Равданы угсаа учир 1733 оны үйл явдалд хамаарахгүй.

Хамгийн боломжит өв тээгчид нь ШУОЗӨ-ны Или жөүн өөлд болон Увс аймгийн дөрвөд, баядууд юм. Гэвч Увс аймгийн Ховд сум, Улаангом сумын 2-р багийн дөрвөдөөр хязгаарлагдаж байна. Шалтгаан нь Или жөүн өөлд 1755–1764 оны хооронд хядлаганд өртөж, ой тайгаар нуугдан амьдарсан, мөн эдүгээ нүүдэллэн малжих

хэв маяг нь суурин байдалтай болсон. Харин Ховд сум, Улаангом сумын 2-р багт энэхүү байгалийн давтамжтай холбогдох өвчин тахал илүү тохиолдож, энэ хэллэгийг мартуулалгүй сануулж байсан бололтой.

Монголчуудын байгалиа хайрлан хамгаалах шашны уламжлалт сэтгэлгээ ба орчин үе

О. ЭРДЭНЭЧИМЭГ

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академи, Философийн Хүрээлэн

С. ЦЭДЭНДАМБА

Монгол Улсын Их Сургууль, Философи Шашин Судлалын Тэнхим

Монгол улсад Бурханы шашин дэлгэрсэн цагаас байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалах, эх болсон зургаан зүйл, хамаг амьтныг хайрлах арга ухаан, тэдгээрийн шүтэлцэн орших хамаарлын хуулийг сургаж ирсэн түүхтэй.

Эрт дээр үеэс Бурханы шашны сүм хийд, лам нар байгаль эх дэлхийгээ хамгаалахад голлох үүрэг гүйцэтгэж ирсэн бөгөөд өнөөдөр дэлхий дахинаа Бурханы шашныг байгальд ээлтэй шашин гэдгийг бүх нийтээрээ хүлээн зөвшөөрч байна. Энэ нь орчин цагт Бурханы шашинтангуудын байгаль орчноо хамгаалах оролцоо хичнээн чухал болохыг сануулж байна. Энэ уламжлал, шашин шүтлэгээрээ дамжуулан уул ус, онгон дагшин байгаль эхээ хайрлан хамгаалж ирсэн зан үйл хэдэн үеэрээ дамжин хадгалагдсаар байна. Өөрөөр хэлбэл онгон дагшин газар нутагт ан ав хийх, газар ухаж хөндөх, гол усаа цэвэр ариун байлгах зэрэг олон хэлбэрээр байгаль эхээ хайрлан хамгаалж ирсэн.

Өнөөдөр дэлхийн улс орнуудын хүн амын өсөлт, глобальчлал, түүнтэй зэрэгцэн хөндөгдөж буй олон сөрөг асуудлаас сэргийлэхийн тулд улс орон бүр өөр өөрийн нөхцөл боломжиндоо тулгуурлан олон талт үйл ажиллагаа явуулж байна. Манай улсад ч байгаль хамгаалах чиглэлээр төр хувийн хэвшил, Төрийн бус байгууллагууд чамгүй олон ажлыг эсдэж санаачлан ажиллаж байгаа ба үүний нэг нь Монголын Бурханы шашины бүх сүм хийдүүдийн төлөөлөгчид хуран чуулсан “Нигүүлсэл ба Байгаль хамгаалал 2010” хурал юм. Тус хурлаар Монголын Бурханы шашинтнуудын Байгаль хамгаалах найман жилийн төлөвлөгөөг боловсруулсан ба 2011 оноос хэрэгжүүлэн ажиллаж байна.

A Tale of Betgeljin Sparrow – An Example of Mongolian Traditional Educational Methods (Бэтгэлжин бор шувууны үлгэр буюу монголчуудын үйлдэн сургахуйн арга ухаан)

D. ERDENESAN

Mongolian State University of Education, Mongolian Language Faculty

It examines the differences between the mentality of the peoples of the West and the East, and how they should affect the methodology of teaching. Here the questions will be discussed since Mongolians have a holistic view of things and general view of things, and Westerners have a particular view of fragmentation, how appropriate are Western teaching methods for Mongolian children? As a result, the advantages of traditional Mongolian memorization methods are illustrated with examples from Mongolian folklore. It is an indisputable fact that fairy tales and riddles have played a significant role in increasing the vocabulary and language skills of Mongolian children, in addition to educating their children through the rich collection of folklore.

At the top of the six apes, by the light of a candle, the old men light a fire and talk about old words. According to famous writer Natsagdorj, during the long winter nights, the children would listen to the stories and fairy tales of old people and grandparents, and the children would be able to relax and enjoy after their day's hard work. Mongolians are people with a rich heritage of heroic epics and fairy tales with thousands of lines of poetry that will melt for tens of days and months, ranging from proverbs, sayings, teachings, and gifts.

Comparative Study of Words Related to Buddhism in Mongolian and Korean Languages On the examples of sources Mongöyuhæ (蒙語類解) and (Panöncibso) (方言集釋)

ERDENETUYA, Pürevdorj

Mongolian State University of Education, Mongolian Language Faculty

This paper will compare the words and concepts related to Buddhism in Mongolian and Korean languages, which have branched from the ancestral Altaic language, in the sources of Mongöyuhæ (蒙語類解) and (Panöncibso) (方言集釋). One of the sources known as “The Three Books for the Study of Mongolian (蒙語類解)” and the similar 5 language dictionary (Panöncibso) (方言集釋) were used as source materials. It is important to bring these sources belonging to the XVII-XVIII centuries into the research circulation, to compare the words and concepts related to Buddhism in the thematic dictionaries and compare in diachrony and synchrony.

Mongöyuhæ (蒙語類解) is a Mongolian-Chinese-Korean dictionary and these sources were in which Mongolian words were transcribed in Korean letters; the words were categorized into the categories of the Oriental

lexicographical tradition such as heaven, human, social, and natural phenomenon, flora, and fauna etc. The semantic classification of the words is divided into 54 categories; there are 1926 in the first volume; 1959 in the second; and 1450 in the additional volume and all in all 5335 words. Panöncibisog (方言集釋) is a dictionary of Mongolian-Chinese-Korean-Manchurian-Japanese languages. The semantic classification of the words is divided into 87 categories and there are 1142 words in the first volume; 1032 in the second; 1107 in the 3rd; and 1033 in the 4th volume; and all in all 4314 words.

Mongolian Translation of the “Journey to the West”: the Narrative of the Monkey King

FENG, Quan

Minzu University of China – Eötvös Loránd University,
Department of Mongolian and Inner Asian Studies

Since the dissemination of the “Journey to the West” in Mongolian language, Mongolian *literati* and folk artists have developed a unique narrative and image of the Monkey King through translation or oral performance.

There are two main Mongolian translations of the “Journey to the West” that have been discovered. One is Arana’s translation in 1721. Another is the anonymous translation. These two translations differ in their translations of the Monkey King’s character, especially with different names of the Monkey King. One of the anonymous translations was transcribed into the Clear Script in 1872, which is among the earliest works of Chinese classic literature transcribed on the Clear Script through traditional Mongolian script. From the content of the anonymous text, sometimes the Monkey King is referred to as Hanuman, and it can be said that the translator considered the Monkey King to be the Hanuman from the Indian Ramayana. This paper first analyzes and explores the analysis of the narrative and the image of Monkey King that appears in these two translations. Secondly, Mongolian *khuurch* Temüre and Rinčin had acted out the “Journey to the West”, thus analyzes the image of the Monkey King as it appears in Mongolian folkloric genre, so-called *khuuriin üliger*, and oral text.

In general, this article will discuss the narrative of Monkey King in the Mongolian translations of the “Journey to the West” and folk literature and study the image of Monkey King in the Mongolian region.

Wildhorse-Power: Nature Protection, Art and Magic in a Mongolian Music Clip

FÜREDI Zoltán

Eötvös Loránd University, Department of Mongolian and Inner Asian Studies

In my presentation, I would like to analyze a Mongolian video clip about Mongolian wild horses and the conservation project aimed at reintroducing wild horses to their original habitat in Mongolia.

The ecological thinking appearing in the clip is deeply rooted in steppe culture: the natural environment is protected by taboos in the Mongol tradition. Every landmark, forest, mountain, river bend has its own guardian, whose unjustified disturbance – in our case, the extermination of wild horses at the beginning of the 20th century – brings trouble to people.

According to the video clip, a kind of magical reparation is realized by reintroducing wild horses.

The “returning” takhis have some kind of wonderful vitality and their arrival and presence has a fertilizing and vitalizing effect both on the natural environment of the Gobi and on the studs of the shepherds, but also on the human world itself. This vital power is the often referred “khiimor”.

In the music clip, the magical system of relations that represents the relationship between the natural environment, wild animals, domestic animals and the human world for Mongolians is expressed with wonderful conciseness.

Орон, хийдийн магтаалын монгол уламжлал

М. ГАНХУЯГ

Өндөр гэгээн Занабазарын нэрэмжит Бурхан Шашны Дээд Сургууль

Монголын уран зохиол тэр дундаа төвд хэлээр зохиогдсон уран зохиолд орон, хийдийн магтаал хэмээх төрөл зүйл буй бөгөөд энэхүү төрлийн магтаал нь энэтхэг, төвдөөс уламжлагдан монгол оронд өөрийн гэсэн онцлогтойгоор хөгжиж ирсэн магтаалын төрөл зүйл юм. Орон хийдийн магтаал нь монгол оронд хэдүй үеэс зохиогдож ирэв?

Энэтхэг, Төвд болоод бусад улс орнуудын оронгийн магтаалтай төстэй хэв шинж бүхий шүлэг найраглалуудаас онцлог ялгаатай байдлаараа монголын төвд хэлт уран зохиолын сонирхолтой судалгааны төрөл зүйл юм.

Энэхүү төрөл зүйлийн магтаал нь хөгжлийн явцад дүр дүрслэл, илэрхийлэл нь олон янзын байр байдалтай дан ганц тухайн газар орноо магтахаас гадна монгол орны түүх, тухайн хийд орны хүрээлэн буй орчин тэдгээрийн нөлөөлөл, тухайн газар орны оршин суугчдад үзүүлж буй нөлөө, ямар номыг бясалган бүтээвээс зохистой болох, хүрээлэн буй орчныг хэрхэн номын утганд ойлгож ухаарахыг зааж зөвлөсөн магтаал

зохиолууд байна. Бурханы шашны шинж байдалтай байхаас гадна иргэний шинж чанартай орон, хийдийн магтаал дуу зэрэг орон, хийдийн магтаалын монгол бичгийн дурсгалууд ч мөн цөөнгүй байдаг аж.

Хэрээний хэл шинжих нэгэн бичгийн тухай

Ч. ГАНСҮХ

Үндэсний Номын Сангийн Монгол Судлал, Гар Бичмэл Номын Сан Хөмрөг
Өтвөш Лорандын нэрэмжит Их Сургууль, Могнол ба Төв Ази Судлалын Тэнхим

Хэрээ хэмээх шувууг монголчууд эртнээс нааш шүтэн биширсээр ирсэн байдаг. Хэрээг монгол ардын хэлц үгэнд хэлэхдээ “Үдээс өмнө Гомбо бурхны хэлмэрч, үдээс хойш чөтгөрийн хэлмэрч хийдэг” гэсэн үг бий. Үүнээс харахад хэрээг ихээхэн чухалчилж үздэгийн нэг жишээ юм.

Энэ удаа Монгол Улсын Үндэсний Номын Сангийн Гар бичмэл-Монгол судлалын сан хөмрөгт хадгалагдаж байгаа хэрээний хэл шинжих хэдэн эх сурвалж байна. Үүнээс 2761/96 дугаартай “Хэрээний дуун аялгуу шинжлэх бичиг” хэмээх нэгэн гар бичмэлийг сонгон авлаа. Учир нь энэхүү гар бичмэл нь бусад эхээсээ бүрэн бүтэн, маш олон мэдээлэл агуулснаараа ихээхэн онцлогтой. Жишээ нь:

Үүр цайхаас наран шингэх хүртэл аль зүгт хандаж дуугарсанаар ямар зүйл тохиох эсэх, монгол 12 цагт дуугарваас ямар ёр болох. Үүнээс гадна ямар авиа гарсанаар юу тохиолдож болох зэргийг нарийн тодорхой бичсэн байна.

